

*Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 06 сарын 12-ны 187 тоот
тушаалын 12 дугаар хавсралт*



ИНД - 67

Иргэний Нисэхийн Дүрэм

Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-67 нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- нисэх багийн гишүүн болон нислэгийн хөдөлгөөний удирдагч Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах;
- Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй байх нөхцөл;
- нисэх багийн гишүүн, нислэгийн хөдөлгөөний удирдагчид хамаарах Эрүүл мэндийн стандарт.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-67-гийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-67, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 03 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 1	2002 оны 01 сарын 30
Нэмэлт, өөрчлөлт 2	2005 оны 09 сарын 14
Нэмэлт, өөрчлөлт 3	2009 оны 09 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 4	2010 оны 05 сарын 07
Нэмэлт, өөрчлөлт 5	2013 оны 01 сарын 22
Нэмэлт, өөрчлөлт 6 (Шинэчлэлт)	2019 оны 06 сарын 12

Тэмдэглэл: ИНД-67-гийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 67-гийн 2007 оны 10 сарын 25-ны А.3-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	1
67.1. Зорилго.....	1
67.3. Нэр томъёо ба товчлол	1
67.4. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх.....	1
В Бүлэг - Эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт	1
67.51. Зорилго.....	1
67.53. Эрүүл мэндийн гэрчилгээний ангилал	2
67.55. Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах	2
67.57. Үзлэгийн дүгнэлт бэлтгэхэд тавих шаардлага	2
67.59. Эрүүл мэндийн үнэлгээний тайлан	3
67.61. Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	3
67.63. Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт	4
67.65. Эрүүл мэндийн гэрчилгээг нөхөн олгох.....	4
67.67. Эрүүл мэндийн заавар	4
67.69. Эрүүл мэндийн нууцлал.....	4
С Бүлэг - Эрүүл мэндийн стандарт	5
67.101. Зорилго.....	5
67.103. 1-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ.....	5
67.105. 2-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ.....	10
67.107. 3-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ.....	15
Д Бүлэг - Эрүүл мэндийн шалгагч	20
67.151. Зорилго.....	20
67.153. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ	20
67.155. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах	20
67.157. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ олгох	20
67.159. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшигчийн эрх	20
67.161. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага.....	21
67.163. Ерөнхий заавар.....	21
Е Бүлэг - Эрүүл мэндийн шалгагчийн үйл ажиллагааны шаардлага	23
67.201. Зорилго.....	23
67.203. Байнгын хэрэгжилт	23
Ү Бүлэг - Даргаас эрх шилжүүлэхэд тавих шаардлага	24
67.251. Зохих ёсоор мэргэшсэн Эрүүл мэндийн шалгагчийг тодорхойлох	24
Г Бүлэг - Нисэхийн шалгагч - нөөц	24
Н Бүлэг - Шилжилтийн зохицуулалт	24
67.351. Шилжилтийн зохицуулалт	24
Хавсралт А - Эрүүл мэндийн шалгагчийн ур чадвар	25

А Бүлэг - Ерөнхий зүйл

67.1. Зорилго

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) нисэх багийн гишүүн болон нислэгийн хөдөлгөөний удирдагчид шаардлагатай Эрүүл мэндийн гэрчилгээ (цаашид ЭМГ гэх) олгох болон эзэмших;
- (2) ЭМГ-ний ангиллын эрүүл мэндийн стандарт;
- (3) Эрүүл мэндийн шалгагчийн (цаашид ЭМШ гэх) гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагаа;
- (4) зохих ёсоор мэргэшсэн, ИНЕГ-т ажилладаггүй ЭМШ-ийг тодорхойлох.

67.3. Нэр томъёо ба товчлол

(a) Энэ Дүрэмд:

Холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, эрүүл мэндийн нөхцөл нь, хэрэв ЭМГ-нд хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн чиг үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй бол **нисэхийн эрүүл мэндийн онцлох шаардлагад** тооцогдоно.

(b) Ажил үүрэг гүйцэтгэх чадвараа гэнэт, эсхүл бусад хэлбэрээр алдах шалтгаан болж байгаа, эсхүл шалтгаан болж болзошгүй эрүүл мэндийн нөхцөлийг нисэхийн эрүүл мэндийн онцлох шаардлагын (цаашид НЭМОШ гэх) эрүүл мэндийн нөхцөлд тооцно.

(c) Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.

67.4. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх

(a) Дарга энэ дүрмийн С Бүлгийн шаардлагаас аливаа этгээдийг чөлөөлөхгүй.

(b) Энэ зүйлийн (a) нь, энэ Дүрмийн дагуу хүсэлт гаргагчид ЭМГ олгохдоо уян хатан хандаж болох Даргын бүрэн эрхэд нөлөөлөхгүй.

В Бүлэг - Эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт

67.51. Зорилго

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

(a) дараах тохиолдолд шаардагдах маягт болон мэдээллийн:

- (1) ЭМГ эзэмших хүсэлт гаргах;
- (2) ЭМГ эзэмших хүсэлт гаргагчид үнэлгээ хийх;

(b) ЭМГ-ний ангилал, хүчинтэй огноо болон үргэлжлэх хугацааны;

(с) Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргах зорилгоор Даргын хүлээн зөвшөөрөхүйц эксперт-эмчийг тодорхойлох шаардлага болон шалгуурын.

67.53. Эрүүл мэндийн гэрчилгээний ангилал

Дарга энэ Дүрмийн дагуу дараах ангиллын ЭМГ олгоно:

- (1) 1-р ангиллын;
- (2) 2-р ангиллын;
- (3) 3-р ангиллын.

67.55. Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

ЭМГ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) Даргын тогтоосон холбогдох маягыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт хүргүүлэх;
- (2) тухайн этгээдийг нотлох дараах аль нэг баримт бичгийг хүргүүлэх:
 - (i) хүчинтэй Монгол Улсын иргэний үнэмлэх;
 - (ii) хүчинтэй Жолооны үнэмлэх;
 - (iii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, фото зурагтай, дүйцэх бусад бичиг баримт;
- (3) хамааралтай бол үзлэгт шаардлагатай дараах баримт бичгийг хүргүүлэх:
 - (i) ЭМГ шаардсан, хүсэлт гаргагчийн эзэмшиж байгаа үнэмлэх;
 - (ii) хүсэлт гаргагчийн хамгийн сүүлд эзэмшиж байсан ЭМГ;
 - (iii) хамгийн сүүлд гаргасан эрүүл мэндийн үнэлгээний тайлан.
- (4) ЭМГ-ний стандартыг хангаж байгааг тодорхойлох зорилгоор Даргын шаардаж болох, сэтгэцэд нөлөөлөх эмийн бодис, согтууруулах ундаа, төрөл бүрийн эм бэлдмэл хэрэглэснээс үүдэлтэй гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийтгүүлж байсан эсэх талаарх мэдээллийг багтаасан, хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн нөхцөл, эсхүл түүхтэй холбоотой мэдээллийг ил болгох, эсхүл ил болгох эрхийг Дарга болон ЭМШ-д олгох.

67.57. Үзлэгийн дүгнэлт бэлтгэхэд тавих шаардлага

Энэ хэсгийн дагуу эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт гаргах зорилгоор, ЭМШ нь:

- (1) дараах үүрэгтэй:
 - (i) хүсэлт гаргагчид эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийхдээ, хүсэлт гаргасан ЭМГ-нд тавих эрүүл мэндийн стандарт болон холбогдох ерөнхий чиглэлийг харгалзан үзэх;
 - (ii) ерөнхий чиглэлд заасан холбогдох маягыг бөглөх;
- (2) ерөнхий чиглэлд өөрөөр заагаагүй бол, энэ Дүрмийн дагуу шаардсан шинжилгээ, үзлэг, эсхүл давтан үзлэгийн хариу нь тухайн шинжилгээ, үзлэг, эсхүл давтан үзлэг хийлгэсэн өдрөөс хойш 90 хоног хэтэрсэн бол түүнд үндэслэн дүгнэлт гаргахгүй байж болно.

67.59. Эрүүл мэндийн үнэлгээний тайлан

Дарга дараах үүрэгтэй:

- (1) анхаарах шаардлагатай эрүүл мэндийн нөхцөлийн дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, ЭМГ эзэмших хүсэлтэд хийсэн үнэлгээ болон, хэрэв ЭМГ олгосон бол тухайн ЭМГ-нд заасан байнгын хяналтын шаардлага болон баталгаажуулсан тэмдэглэлийг Ерөнхий чиглэлд заасан холбогдох маягтын дагуу үнэлгээний тайланд тэмдэглэх;
- (2) хувийг хүсэлт гаргагчид хүргүүлэх.

67.61. Эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацаа

(a) Энэ зүйлийн (c) болон (e)-г харгалзан, Дарга ЭМГ-г дараах хугацаагаар олгож болно:

- (1) 1-р ангиллын ЭМГ:
 - (i) 6 сар хүртэлх хугацаагаар, ганц-нисгэгчтэй зорчигч тээвэрлэх арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, хэрэв хүсэлт гаргагч нь ЭМГ олгох үед 40, эсхүл түүнээс дээш настай бол; эсхүл
 - (ii) 12 сар хүртэлх хугацаагаар, бусад бүх тохиолдолд;
- (2) 2-р ангиллын ЭМГ:
 - (i) 60 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40-өөс доош настай бол; эсхүл
 - (ii) 24 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40, эсхүл түүнээс дээш настай бол;
- (3) 3-р ангиллын ЭМГ:
 - (i) 48 хүртэлх сарын хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40-өөс доош настай бол; эсхүл
 - (ii) 24 сар хүртэлх хугацаагаар, хэрэв ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 40, эсхүл түүнээс дээш настай бол.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон ЭМГ нь:

- (1) олгосон өдрөөс эхлэн хүчинтэй болно;
- (2) дараахаас бусад тохиолдолд, хүчинтэй хугацаа нь дуусах хүртэл хүчинтэй хэвээр байна:
 - (i) тухайн ЭМГ-г хураасан; эсхүл
 - (ii) тухайн эзэмшигч дараагийн, эсхүл нөхөн олгосон ЭМГ авсан.

(c) Хэрэв шинэ ЭМГ олгох үед хүсэлт гаргагч нь 30 хоног, эсхүл түүнээс бага хугацаанд дуусах хүчинтэй ЭМГ эзэмшиж байгаа бол Дарга шинэ ЭМГ-г энэ зүйлийн (a)-д заасан хугацаанаас урт, өмнөх хүчинтэй ЭМГ-ний хугацаа дууссан үед шинээр олгож болох гэрчилгээний хүчинтэй хугацаагаар олгож болно.

(d) Энэ зүйлийн (c) нь зөвхөн дараах нөхцөлд хамаарна, хэрэв:

- (1) Дарга хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн дагуу зөвшөөрсөн максимум хугацаагаар шинэ ЭМГ эзэмших шалгуурыг хангаж байгааг тогтоосон бол;
- (2) Дарга өмнөх гэрчилгээний дуусах хугацааг 60-аас дээш хоногоор сунгаагүй бол.

(е) Дарга, тухайн ЭМГ олгох үед 40, эсхүл түүнээс дээш настай хүсэлт гаргагчид энэ зүйлийн (а)-д заасны дагуу 1-р ангиллын ЭМГ олгохдоо энэ зүйлийн (а)(1)(i)-д заасан нэг бүтэн хугацаа болон (а)(1)(ii)-т заасан нэг бүтэн үргэлжлэх хугацаагаар олгож болно.

67.63. Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт

Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргах зорилгоор эксперт-эмчийг хүлээн зөвшөөрөхүйц болохыг тодорхойлохын өмнө Дарга дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) эксперт-эмч нь нарийн мэргэжлийн эмч байх;
- (2) эксперт-эмч нь дараах байгууллагад ажиллаж, шаардлагатай түвшинд мэргэшсэн ба туршлагатай байх:
 - (i) нисэхийн анагаах ухааны; эсхүл
 - (ii) хэрэв тодорхой нөхцөлд Дарга шаардлагатай гэж үзвэл, итгэмжлэгдсэн эрүүл мэндийн дүгнэлт гаргадаг эмнэлгийн салбарт.

67.65. Эрүүл мэндийн гэрчилгээг нөхөн олгох

(а) ЭМГ эзэмшдэг этгээд нь дараах тохиолдолд, гэрчилгээг нөхөн авах тухай хүсэлтээ Даргад бичгээр гаргаж болно, хэрэв гэрчилгээ нь:

- (1) гээгдсэн, алдагдсан, эсхүл үрэгдсэн бол; эсхүл
- (2) гэрчилгээн дээрх дэлгэрэнгүй мэдээлэл нь уншигдах боломжгүй гэмтсэн бол.

(б) Гэрчилгээ нөхөн олгох хүсэлт гаргагч нь зохих төлбөрийн баримтыг дараах баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) ЭМГ-г гээсэн, алдсан, эсхүл үрэгдсэн тухай албан ёсны мэдүүлэг; эсхүл
- (2) гэмтсэн гэрчилгээ.

67.67. Эрүүл мэндийн заавар

Дарга өөрийн гаргасан ерөнхий чиглэл болон ЭМГ-ний хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг агуулсан, эмчилгээний, захиргааны болон эрх зүйн талаарх мэдээлэл, зөвлөмж материалыг багтаасан эрүүл мэндийн заавар гаргах үүрэгтэй.

67.69. Эрүүл мэндийн нууцлал

Энэ дүрэм нь Хувь хүний нууцын тухай хуулийн зүйл заалтыг сулруулах, үгүйсгэх утга санааг агуулаагүй болно.

С Бүлэг - Эрүүл мэндийн стандарт

67.101. Зорилго

Энэ Бүлэг нь ЭМГ-ний стандартыг тогтооно.

67.103. 1-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ

(a) Энэ зүйлийн (b) - (m)-д заасан стандартыг хангаж байгаа хүсэлт гаргагчийг 1-р ангиллын ЭМГ-ний стандарт хангасанд тооцно.

Ерөнхий шаардлага

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) хэвийн бус байдал;
 - (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал);
 - (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц;
 - (v) хорт хавдрын явц;
 - (vi) ядаргаа үүсгэх нөхцөл;
 - (vii) халдвар; тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний шийдэл, эсхүл аль аль нь тодорхой байхаас бусад тохиолдолд;
- (3) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 1-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх:
 - (i) эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл
 - (ii) эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй гаж нөлөөнд орсон.

Мэдрэлийн эрхтэн тогтолцоо

(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг;
 - (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин;
 - (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал;
 - (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл;

- (v) солиорол;
 - (vi) зан чанарын эмгэг;
 - (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз;
 - (viii) сэтгэл гутрал;
 - (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг;
 - (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар;
- (3) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (4) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 1-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (5) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 1-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.

Зүрх судасны эрхтэн тогтолцоо

(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
- (i) зүрхний титэм судасны өвчин;
 - (ii) зүүн багцын салааны хориг;
 - (iii) баруун багцын салааны хориг; ишемигийн шалтгааныг арилгасан байхаас бусад тохиолдолд;
 - (iv) цусны даралт тогтворгүй ихсэх;
 - (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал;
 - (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал;
- (3) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх;
- (4) зүрх судасны өвчний өндөр эрсдэлтэй хүчин зүйл байхгүй байх; зүрхний булчингийн перфузийн хэвийн үйл ажиллагааг хангаж чаддаг байхаас бусад тохиолдолд.

Амьсгалын замын эрхтэн тогтолцоо

(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;

- (2) энэ зүйлийн (е)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний оношгүй, эсхүл түүхгүй байх; зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тохирох хяналтад байгаагаас бусад тохиолдолд.

Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо

(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцооны, хоол тэжээлийн, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
- (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) чихрийн шижингийн эсрэг эмийн бодис хэрэглэхгүйгээр тухайн нөхцөлийг хангалттай түвшинд хянадаг байх; эсхүл
 - (ii) хэрэв тухайн нөхцөлийг хянахын тулд чихрийн шижингийн эсрэг эмийн бодис уухаар хэрэглэдэг бол:
 - (iia) тухайн нөхцөл нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх;
 - (iib) инсулин хэрэглэдэггүй байх;
 - (iic) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, хэрэглэж байгаа уудаг эмийн бодисыг дангаар болон хавсран хэрэглэх нь 1-р ангиллын ЭМГ-нд хамаарах эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй ба бараг нөлөөлөхөөргүй байх.

Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо

(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны өвчний оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) дэлүү томрох; цус төлжүүлэлт /миелопролифератив/ болон халдварын шалтгааныг арилгасан байхаас бусад тохиолдолд;
 - (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох;
 - (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл;
 - (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл.

Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо

(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин;
 - (ii) шээс-бэлгийн замын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.

Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо

(i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
 - (ii) жирэмслэлт.

Яс-булчингийн эрхтэн тогтолцоо

(j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах яс-булчингийн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.

Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо

(k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (k)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;

- (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
- (iii) евстахиевийн сувгийн битүүрэл, эсхүл дунд чихний хэвийн бус байдал;
- (iv) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.

Сонсгол

(l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах сонсголын эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, аль ч чихний сонсох чадварын дутагдал нь дараахаас хэтэрсэн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) 500, 1000, 2000 Гц-ийн давтамж бүрд 35 дБ; эсхүл
 - (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000 Гц-ийн давтамжид 50 дБ.

Хараа

(m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах харааны эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтийн хэвийн бус байдал;
 - (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт;
- (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/9, эсхүл илүү сайн харах болон хос хараа нь 6/6, эсхүл илүү сайн харах;
- (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30 - 50 см-ийн хоорондох зайнаас илүү сайн харах болон дундын хараа нь N14 дүрсийг, эсхүл хос хараагаар 1 м-ийн зайнаас илүү сайн харах;
- (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгах чадварын дутагдал илрээгүй байх.

67.105. 2-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ

(a) Энэ зүйлийн (b) - (m)-д заасан стандартыг хангаж байгаа хүсэлт гаргагчийг 2-р ангиллын ЭМГ-ний стандартыг хангасанд тооцно.

Ерөнхий шаардлага

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) хэвийн бус байдал;
 - (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал);
 - (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц;
 - (v) хорт хавдрын явц;
 - (vi) ядаргаа үүсгэх нөхцөл;
 - (vii) халдвар; тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний шийдэл, эсхүл аль аль нь тодорхой байхаас бусад тохиолдолд;
- (3) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 2-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх:
 - (i) эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл
 - (ii) эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй гаж нөлөөнд орсон.

Мэдрэлийн эрхтэн тогтолцоо

(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг;
 - (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин;
 - (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал;
 - (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл;
 - (v) солиорол;
 - (vi) зан чанарын эмгэг;
 - (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз;
 - (viii) сэтгэл гутрал;
 - (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг;
 - (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар;

- (3) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (4) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 2-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (5) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 2-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.

Зүрх судасны эрхтэн тогтолцоо

(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) зүрхний титэм судасны өвчин;
 - (ii) зүүн багцын салааны хориг;
 - (iii) баруун багцын салааны хориг; ишемигийн шалтгааныг арилгасан байхаас бусад тохиолдолд;
 - (iv) цусны даралт тогтворгүй ихсэх;
 - (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал;
 - (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал;
- (3) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх;
- (4) зүрх судасны өвчний өндөр эрсдэлтэй хүчин зүйл байхгүй байх; зүрхний булчингийн перфузийн хэвийн үйл ажиллагааг хангаж чаддаг байхаас бусад тохиолдолд.

Амьсгалын замын эрхтэн тогтолцоо

(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний оношгүй, эсхүл түүхгүй байх; тохирох, найдвартай хяналтад байгаагаас бусад тохиолдолд.

Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо

(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцооны, хоол тэжээлийн, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
- (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) чихрийн шижингийн эсрэг эмийн бодис хэрэглэхгүйгээр тухайн нөхцөлийг хангалттай түвшинд хянадаг байх; эсхүл
 - (ii) хэрэв тухайн нөхцөлийг хянахын тулд чихрийн шижингийн эсрэг эмийн бодис уухаар хэрэглэдэг бол:
 - (iia) тухайн нөхцөл нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх;
 - (iib) инсулин хэрэглэдэггүй байх;
 - (iic) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, хэрэглэж байгаа уудаг эмийн бодисыг дангаар болон хавсран хэрэглэх нь 2-р ангиллын ЭМГ-нд хамаарах эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй ба бараг нөлөөлөхөөргүй байх.

Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо

(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны өвчний оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) дэлүү томрох; цус төлжүүлэлт /миелопролифератив/ болон халдварын шалтгааныг арилгасан байхаас бусад тохиолдолд;
 - (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох;
 - (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл;
 - (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл.

Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо

(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин;
 - (ii) шээс-бэлгийн замын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.

Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо

(i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
 - (ii) жирэмслэлт.

Яс - булчингийн эрхтэн тогтолцоо

(j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах яс-булчингийн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.

Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо

(k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (k)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;

- (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
- (iii) евстахиевийн сувгийн битүүрэл, эсхүл дунд чихний хэвийн бус байдал;
- (iv) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.

Сонсгол

(l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах сонсголын эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дуу хоолойн тестэд аль ч чихний сонсох чадварын дутагдал илрээгүй, эсхүл дараахаас хэтрээгүй байх:
 - (i) 500, 1000, 2000 Гц-ийн давтамж бүрд 35 дБ; эсхүл
 - (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000 Гц-ийн давтамжид 50 дБ.

Хараа

(m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах харааны эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтийн хэвийн бус байдал;
 - (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт;
- (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/12, эсхүл илүү сайн харах болон хос хараа нь 6/9, эсхүл илүү сайн харах;
- (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30 - 50 см-ийн хоорондох зайнаас илүү сайн харах;
- (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгах чадварын дутагдал илрээгүй байх.

67.107. 3-р ангиллын Эрүүл мэндийн гэрчилгээ

(a) Энэ зүйлийн (b) - (m)-д заасан стандартыг хангаж байгаа хүсэлт гаргагчийг 3-р ангиллын ЭМГ-ний стандартыг хангасанд тооцно.

Ерөнхий шаардлага

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах эрүүл мэндийн нөхцөлгүй байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) хэвийн бус байдал;
 - (ii) хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл өвчтэй (идэвхтэй, эсхүл нуугдмал);
 - (iii) осол, гэмтэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iv) физиологийн, эсхүл эмгэг зүйн явц;
 - (v) хорт хавдрын явц;
 - (vi) ядаргаа үүсгэх нөхцөл;
 - (vii) халдвар; тохирох эмчилгээ, эсхүл эмчилгээний шийдэл, эсхүл аль аль нь тодорхой байхаас бусад тохиолдолд;
- (3) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 3-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй дараах нөхцөлгүй байх:
 - (i) эм, эмийн бодис, эмийн бэлдмэл хэрэглэдэг, эсхүл тухайн цаг хугацаанд эмчилгээнд бэлдэж байгаа, эсхүл хийлгэж байгаа; эсхүл
 - (ii) эм, эмийн бодис, эмийн бэлдмэл, эмчилгээний бэлтгэл, эсхүл эмчилгээнээс үүдэлтэй гаж нөлөөнд орсон.

Мэдрэлийн эрхтэн тогтолцоо

(c) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах мэдрэлийн, мэдрэлийн мэс заслын, сэтгэцийн, эсхүл сэтгэл зүйн нөхцөлийн, эсхүл зан төлөвийн, эсхүл танин мэдэхүйн эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) мэдрэлийн эрхтэн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгийн өвчин, эсхүл эмгэг;
 - (ii) мигрень /толгой таллаж өвдөх/, эсхүл бусад хүнд хэлбэрийн толгойн өвчин;
 - (iii) сэтгэхүйн, эсхүл үйл хөдлөлийн хэвийн бус байдал;
 - (iv) сэтгэцийн өөрчлөлтийн нөхцөл;
 - (v) солиорол;
 - (vi) зан чанарын эмгэг;
 - (vii) сэтгэцийн хэвийн бус байдал, эсхүл невроз;
 - (viii) сэтгэл гутрал;
 - (ix) бэртлийн дараах стрессийн эмгэг;
 - (x) мэдрэлийн мэс засал, эсхүл тархины гэмтлийн үр дагавар;

- (3) энэ зүйлийн (c)(1)-ээр хязгаарлахгүйгээр, татаж унадаг өвчний, эсхүл түүнээс үүдэлтэй таталт өгдөг эрсдэл ихэссэнтэй холбоотой бусад нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (4) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 3-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (5) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, 3-р ангиллын ЭМГ-д хамаарах эрхийг аюулгүй хэрэгжүүлэх, эсхүл тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэдэггүй байх.

Зүрх судасны эрхтэн тогтолцоо

(d) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах зүрх судасны, эсхүл цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) зүрхний титэм судасны өвчин;
 - (ii) зүүн багцын салааны хориг;
 - (iii) баруун багцын салааны хориг; ишемигийн шалтгааныг арилгасан байхаас бусад тохиолдолд;
 - (iv) цусны даралт тогтворгүй ихсэх;
 - (v) зүрхний булчингийн, хавхлагын, эсхүл дамжуулах тогтолцооны хэвийн бус байдал;
 - (vi) зүрхний хэмнэлийн хэвийн бус байдал;
- (3) энэ зүйлийн (d)(1)-ээр хязгаарлахгүйгээр, зүрхний электрон төхөөрөмж шаарддаг эмгэггүй байх;
- (4) зүрх судасны өвчний өндөр эрсдэлтэй хүчин зүйл байхгүй байх; зүрхний булчингийн перфузийн хэвийн үйл ажиллагааг хангаж чаддаг байхаас бусад тохиолдолд.

Амьсгалын замын эрхтэн тогтолцоо

(e) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах амьсгалын замын эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (e)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох гуурсан хоолойн багтраа өвчний оношгүй, эсхүл түүхгүй байх; зөвхөн урьдчилан сэргийлэх зорилгоор кортикостероид эмчилгээ хэрэглэдэг, тохирох хяналтад байгаагаас бусад тохиолдолд.

Хоол боловсруулах болон дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцоо

(f) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах хоол боловсруулах, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) хоол боловсруулах эрхтэн, эсхүл түүний дайвар эрхтний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) энэ хэсгийн (3)-т зааснаас бусад, бодисын солилцооны, хоол тэжээлийн, эсхүл дотоод шүүрлийн булчирхайн эмгэг;
- (3) энэ зүйлийн (f)(1)-ээр хязгаарлахгүйгээр, дараахаас бусад тохиолдолд, чихрийн шижин, эсхүл хэвийн бус глюкозын ямар ч шинж тэмдгийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) чихрийн шижингийн эсрэг эмийн бодис хэрэглэхгүйгээр тухайн нөхцөлийг хангалттай түвшинд хянадаг байх; эсхүл
 - (ii) хэрэв тухайн нөхцөлийг хянахын тулд чихрийн шижингийн эсрэг эмийн бодис уухаар хэрэглэдэг бол:
 - (iia) тухайн нөхцөл нь эмчийн тогтмол үзлэг, хяналтад байх;
 - (iib) инсулин хэрэглэдэггүй байх;
 - (iic) холбогдох ерөнхий чиглэлийн хувьд, хэрэглэж байгаа уудаг эмийн бодисыг дангаар болон хавсран хэрэглэх нь 3-р ангиллын ЭМГ-нд хамаарах эрх, үүргээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй ба бараг нөлөөлөхөөргүй байх.

Цус болон дархлааны эрхтэн тогтолцоо

(g) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах цус болон дархлааны эрхтэн тогтолцооны өвчний оношгүй, эсхүл түүхгүй байх;
- (2) энэ зүйлийн (g)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) дэлүү томрох; цус төлжүүлэлт /миелопролифератив/ болон халдварын шалтгааныг арилгасан байхаас бусад тохиолдолд;
 - (ii) тодорхой хэсгийн, эсхүл бүх биеийн тунгалгийн булчирхай томрох;
 - (iii) цусны өвчин, эсхүл цус, эсхүл түүний бүрдэл хэсгийн өвчний нөхцөл;
 - (iv) дархлаа сулрах, эсхүл хэт идэвхжихтэй холбоотой эмгэг, эсхүл нөхцөл.

Шээс - бэлгийн замын эрхтэн тогтолцоо

(h) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) НЭМОШ-д хамаарах шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;

- (2) энэ зүйлийн (h)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) шээс-бэлгийн замын эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал, эсхүл өвчин;
 - (ii) шээс-бэлгийн замын өвчлөл, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) бөөр, эсхүл шээсний зам бөглөрсөн, эсхүл бөглөрөх эрсдэл ихэссэн.

Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо

- (i) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
 - (1) НЭМОШ-д хамаарах нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
 - (2) энэ зүйлийн (i)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) сарын тэмдгийн мөчлөгийн алдагдал;
 - (ii) жирэмслэлт.

Яс - булчингийн эрхтэн тогтолцоо

- (j) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
 - (1) НЭМОШ-д хамаарах яс-булчингийн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
 - (2) энэ зүйлийн (j)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин-шөрмөсний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) арьс, холбогч эд, яс, үе мөч, булчин, шөрмөс эсхүл булчин шөрмөсний өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар.

Чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцоо

- (k) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
 - (1) НЭМОШ-д хамаарах чих, хамар, хоолойн эрхтэн тогтолцооны нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
 - (2) энэ зүйлийн (k)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) гадна, дунд, эсхүл дотор чихний хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) шүд, ам, эсхүл амьсгалын дээд замын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (iii) тэнцвэрийн эрхтэн тогтолцооны хэвийн бус байдал.

Сонсгол

- (l) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
 - (1) НЭМОШ-д хамаарах сонсголын эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
 - (2) энэ зүйлийн (l)(1)-ээр хязгаарлахгүйгээр, аль ч чихний сонсох чадварын дутагдал нь дараахаас хэтэрсэн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) 500, 1000, 2000 Гц-ийн давтамж бүрд 35 дб; эсхүл
 - (ii) НЭМОШ-д хүргэж болох 3000 Гц-ийн давтамжид 50 дб.

Хараа

- (m) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
 - (1) НЭМОШ-д хамаарах харааны эмгэгийн оношгүй, эсхүл түүхгүй байх;
 - (2) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох, дараах тодорхой эрүүл мэндийн нөхцөлийн оношгүй, эсхүл түүхгүй байх:
 - (i) нүд, эсхүл түүний дайврын хэвийн бус байдал, өвчин, эсхүл эмгэг явц;
 - (ii) нүд, эсхүл түүний дайврын өвчин, эсхүл бэртэл, эсхүл мэс заслын үр дагавар;
 - (iii) харааны талбайн, эсхүл хос харааны үзүүлэлтийн хэвийн бус байдал;
 - (iv) мэс заслаас үүдэлтэй аль нэг нүдний харааны хугарлын өөрчлөлт;
 - (3) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, холын хараа нь хоёр нүдэнд тус тусдаа шилтэй, эсхүл шилгүй 6/9, эсхүл илүү сайн харах болон хос хараа нь 6/6, эсхүл илүү сайн харах;
 - (4) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, ойрын хараа нь шилтэй, эсхүл шилгүйгээр N5-ын дүрсийг, эсхүл хос хараагаар 30 - 50 см-ийн хоорондох зайнаас илүү сайн харах болон дундын хараа нь N14 дүрсийг, эсхүл хос хараагаар 1 м-ийн зайнаас илүү сайн харах;
 - (5) энэ зүйлийн (m)(1)-ээр хязгаарлахгүйгээр, НЭМОШ-д хүргэж болох өнгө ялгах чадварын дутагдал илрээгүй байх.

D Бүлэг - Эрүүл мэндийн шалгагч

67.151. Зорилго

Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) ЭМШ-ийг томилох;
- (2) зохих ёсоор мэргэшсэн ИНЕГ-т ажилладаггүй ЭМШ-ийг томилох.

67.153. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ

Дарга энэ Дүрмийн дагуу дараах ЭМШ-ийн гэрчилгээ олгож болно:

- (1) ЭМШ Гэрчилгээ-1;
- (2) ЭМШ Гэрчилгээ-2;
- (3) ЭМШ-Тусгай Гэрчилгээ.

67.155. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(a) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч этгээд нь Даргын шаардсан холбогдох маягтыг бөглөж, дараах баримтын хамт хүргүүлэх үүрэгтэй:

- (1) 67.163-т шаардсан Ерөнхий заавар;
- (2) зохих төлбөрийн баримт.

(b) ЭМШ-ийн гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргагч нь Даргын шаардсан холбогдох маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт гэрчилгээнд заасан сунгуулах хугацаанаас ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө, эсхүл хэрэв хугацаа заагаагүй бол гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас ажлын 30 хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

67.157. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ олгох

(a) Энэ Дүрмийн хэрэгжилтийг харгалзан хэрэв Дарга тухайн этгээдийг 67.161-д заасан гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан гэж үзвэл, 61.155-ийн дагуу хүсэлт гаргагчид ЭМШ-ийн гэрчилгээ олгох үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, Дарга шаардлагатай гэж үзсэн нөхцөлд, 67.161-т заасан гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангаагүй дараах этгээдэд ЭМШ-ийн Тусгай гэрчилгээ олгож болно, хэрэв:

- (1) тухайн этгээд нь нарийн мэргэжлийн эмч бол;
- (2) Дарга, тухайн этгээдэд ЭМШ-ийн Тусгай гэрчилгээ олгох онцгой нөхцөл үүссэн, эсхүл газарзүйн нөхцөл байдлаас шалтгаалсан, эсхүл үйл ажиллагааны тусгай нөхцөл байдал үүссэн гэж үзвэл.

67.159. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшигчийн эрх

Дараах хүчинтэй гэрчилгээ эзэмшдэг этгээд нь:

- (1) ЭМШ Гэрчилгээ-1 эзэмшдэг бол аливаа ангиллын ЭМГ олгох зорилгоор эрүүл мэндийн үзлэг;

- (2) ЭМШ Гэрчилгээ-2 эзэмшдэг бол 2-р ангиллын ЭМГ олгох зорилгоор эрүүл мэндийн үзлэг;
- (3) ЭМШ-Тусгай Гэрчилгээ эзэмшдэг бол Даргын бичгээр өгсөн чиглэлийн дагуу ЭМГ олгох зорилгоор эрүүл мэндийн үзлэг хийж болно.

67.161. Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж байгаа этгээдийг дараах тохиолдолд, тухайн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасанд тооцно, хэрэв тухайн этгээд нь:

- (1) нарийн мэргэжлийн эмч бол;
- (2) дараах шаардлагыг хангасан бол:
 - (i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн анагаах ухааны сургалтыг амжилттай дүүргэсэн байх;
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэхийн анагаах ухааны эрх зүйн сургалтыг амжилттай дүүргэсэн байх;
 - (iii) Хавсралт А-д заасан холбогдох ур чадварыг хангаж байгаагаа Даргад батлан харуулсан байх,
- (3) эрүүл мэндийн үзлэгийг, Эрүүл мэндийн зааварт шаардсан стандартын дагуу хийх зорилгоор, зориулалтын эмчилгээний, захиргааны болон холбогдох байгууламжид нэвтрэх эрхтэй бол;
- (4) анагаахын англи хэлээр үр дүнтэй харилцах чадвартай бол;
- (5) 67.163-т заасан Ерөнхий зааврын шаардлагыг хангасан бол.

67.163. Ерөнхий заавар

(a) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж байгаа этгээд нь дараах мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад ирүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар нь дараах шаардлагыг хангаж байгааг бататгаж тухайн этгээд гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) тухайн этгээдийн нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагааны дадлага туршлагыг нягт нямбай тодорхойлох ба 67.161-ийн байнгын хэрэгжилтийг бататгах арга хэлбэр болон аргачлалыг харуулсан байх;
 - (ii) тухайн этгээд болон түүнтэй хамт нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтан байнга дагаж мөрддөг байх;
- (2) тухайн этгээдийн нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагааны цар хүрээний тодорхойлолт;
- (3) тухайн этгээдийн, нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтны албан тушаал, овог нэр;
- (4) энэ хэсгийн (3)-т заасан ажилтны үүрэг ба хариуцлага;
- (5) тухайн этгээдийн, нисэхийн анагаахын үйл ажиллагаа эрхлэх байрлалын жагсаалт;
- (6) тухайн этгээд, эрүүл мэндийн үзлэгийг, Эрүүл мэндийн зааварт шаардсан стандартын дагуу хийх зорилгод шаардлагатай эмчилгээний, захиргааны болон холбогдох байгууламжид нэвтрэх эрхтэй болохыг харуулсан дэлгэрэнгүй мэдээлэл;

- (7) дараах шаардлагыг багтаасан Даргатай харилцах журам:
- (i) ЭМГ эзэмших хүсэлтийг, Даргаар үнэлгээ хийлгэхээр хүргүүлэх;
 - (ii) хамааралтай бол ЭМГ эзэмшдэг этгээдийн эрүүл мэндийн нөхцөлийн өөрчлөлт, эсхүл тухайн этгээдийн ЭМГ-д хамаарах эрхээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлж болох, өмнө нь илэрч байгаагүй эрүүл мэндийн нөхцөл үүссэн талаар мэдээлэх;
 - (iii) энэ зүйлийн (a)(2), (3), (4), эсхүл (5)-д заасан дэлгэрэнгүй мэдээллийн санал болгож байгаа өөрчлөлтийн талаар урьдчилан мэдээлэх;
- (8) тухайн этгээдийн 67.203-т заасан шаардлагын байнгын хэрэгжилтийг бататгах арга хэлбэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) дараах ажлыг зохих ёсоор гүйцэтгэх тогтолцоо болон журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:
- (i) эмнэлгийн төхөөрөмжийн хяналт, үзлэг шалгалт, тест болон тохируулга хийх;
 - (ii) тухайн этгээдийн, нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын өөрчлөлт болон хяналт;
 - (iii) бүртгэлийг ялгаж тодорхойлох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, засварлах болон устгах;
 - (iv) (9)(i), (9)(ii) болон (9)(iii)-т заасан ажил үүргийг гүйцэтгэх ажилтны сургалт, үнэлгээ хийх болон эрх олгох;
- (10) тухайн этгээдийн мэргэжлийн ажил үүргээс үүдэлтэй ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, удирдах журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (11) тухайн этгээдийн нисэхийн эрүүл мэндийн үйл ажиллагаа Ерөнхий зааврын дагуу явагдаж байгааг бататгах, тухайн жилийн дотоод чанар баталгаажуулалтын хяналтын хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (12) дараах журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:
- (i) Ерөнхий зааварт хяналт тавих, өөрчлөлт оруулах;
 - (ii) энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгааг бататгах;
 - (iii) Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан даруйд нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад цаг алдалгүй хүргүүлэхийг бататгах;
 - (iv) Ерөнхий зааврын хувийг бүх ажилтанд хүргүүлэх.
- (b) Тухайн этгээдийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байна.

Е Бүлэг - Эрүүл мэндийн шалгагчийн үйл ажиллагааны шаардлага

67.201. Зорилго

Энэ Бүлэг нь, ЭМШ-ийн үйл ажиллагаанд хамаарах зохицуулалтын шаардлагыг тогтооно.

67.203. Байнгын хэрэгжилт

(а) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) Ерөнхий зааварт заасан үзлэгийн байр бүрд, Ерөнхий зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалах;
- (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам, тогтолцоо болон хөтөлбөрийг дагаж мөрдөх (ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой журмыг багтаасан байна);
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтанд ажил үүргээ гүйцэтгэхдээ байнга ашиглахад боломжтой байлгах;
- (4) D Бүлэгт заасан ЭМШ-ийн гэрчилгээнд хамаарах бүх шаардлагыг байнга хангах;
- (5) Даргын шаардаж болох, нисэхийн анагаахын болон нисэхийн хууль, дүрмийн байнгын сургалтын курст хамрагдах;
- (6) Даргын гаргасан ерөнхий чиглэл болон яаралтай удирдамжийг дагаж мөрдөх;
- (7) эрүүл мэндийн зааврын хамгийн сүүлчийн, шинэчилсэн хувийг хадгалах;
- (8) ЭМГ эзэмших хүсэлт гаргагч бүрийн үзлэгийн бүрэн гүйцэд бүртгэлийг хадгалж байгааг бататгах;
- (9) холбогдох утас, факс, хаягт өөрчлөлт орсон тохиолдолд, тухайн өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөрчлөлт орсон өдрөөс хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгдэх.

(b) Дарга, 67.163 (a)(7)(iii)-т заасан өөрчлөлтийг оруулах үед, эсхүл өөрчлөлтийн дараа ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээдийн ажиллах нөхцөлийг тогтоож болно.

(c) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан нөхцөлийг дагаж мөрдөх;
- (2) энэ зүйлийн (b)-д, тодорхойлсон өөрчлөлт нь ЭМШ-ийн гэрчилгээнд өөрчлөлт оруулахыг шаардсан тохиолдолд, гэрчилгээг Даргад цаг алдалгүй хүргүүлэх;
- (3) нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс Дарга шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах.

F Бүлэг - Даргаас эрх шилжүүлэхэд тавих шаардлага

67.251. Зохих ёсоор мэргэшсэн Эрүүл мэндийн шалгагчийг тодорхойлох

Энэ Дүрмийн дагуу эрх шилжүүлэх зорилгоор тухайн этгээдийг дараах тохиолдолд, зохих ёсоор мэргэшсэн ЭМШ гэж үзнэ, хэрэв:

- (1) тухайн этгээд нь:
 - (i) аливаа ангиллын ЭМГ-ний хувьд, ЭМШ Гэрчилгээ-1 эзэмшдэг бол; эсхүл
 - (ii) 2-р ангиллын ЭМГ-ний хувьд, ЭМШ Гэрчилгээ-2 эзэмшдэг бол;
- (2) Дарга тухайн этгээдийг дараах шаардлагыг хангасан гэж үзвэл:
 - (i) зайлшгүй шаардлагатай ур чадвар, туршлагатай байх;
 - (ii) нисэхийн эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлтийн бодлого, журмын талаарх мэдлэгтэй байх;
- (3) Даргын шаардаж болох, нисэхийн анагаахын болон нисэхийн хууль, дүрмийн байнгын сургалтын курст хамрагддаг бол;
- (4) Дарга, тухайн этгээдийг ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох журмыг дагаж мөрддөг гэж үзвэл.

G Бүлэг - Нисэхийн шалгагч - нөөц

H Бүлэг - Шилжилтийн зохицуулалт

67.351. Шилжилтийн зохицуулалт

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, хэрэв энэ дүрэм хүчинтэй болохоос өмнө ЭМШ Гэрчилгээ-1, эсхүл ЭМШ Гэрчилгээ-2 шинээр авах, эсхүл сунгах хүсэлтийг Дарга хүлээж авсан боловч шийдвэрлээгүй байсан бол Дарга гэрчилгээг шинээр олгох, эсхүл сунгаж болно.

(b) Хэрэв энэ зүйлийн (a) хамааралтай бол, гэхдээ хэрэв газарзүйн байршлаас шалтгаалсан тодорхой нөхцөлд тулгуурлан гэрчилгээ шинээр олгох, эсхүл сунгахаас бусад тохиолдолд, хүсэлт гаргагч нь Нисэхийн эрүүл мэндийн шилжилтийн үеийн шалгуурын (Aviation Medical Transitional Criteria) Хавсралт 1-д заасан холбогдох ур чадварыг хангаагүй бол Дарга ЭМШ Гэрчилгээ-2 шинээр авах, эсхүл сунгуулах хүсэлтийг хүлээн авахгүй.

(c) ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээд нь энэ дүрэм хүчинтэй болсон өдрөөс хойш 6 сарын дотор, 67.163-ын шаардлагыг бүрэн хангасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) Ерөнхий зааврыг Даргад хүргүүлсэн байхыг шаардсан өдрийг хүртэл ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшдэг этгээдийг Ерөнхий заавартай холбоотой E Бүлэгт заасан үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөхийг шаардахгүй.

(e) Хэрэв энэ дүрэм хүчинтэй болохоос өмнө ЭМГ эзэмших хүсэлтийг Дарга хүлээн авсан боловч, шийдвэрлээгүй байсан бол хүсэлт гаргах үед хүчинтэй үйлчилж байсан дүрмийн дагуу хүсэлтийг шийдвэрлэнэ.

Хавсралт А - Эрүүл мэндийн шалгагчийн ур чадвар

Эрүүл мэндийн шалгагчийн гэрчилгээ эзэмшихэд шаардлагатай ур чадвар

Хүсэлт гаргагч нь ЭМШ-ийн гэрчилгээ эзэмшихийн тулд ерөнхий шаардлагыг хангасан байхаас гадна, ЭМШ-ийн ажил үүргийг хэвийн гүйцэтгэх хангалттай түвшний ур чадвар, туршлагатай болохоо баталж харуулах шаардлагатай. Үндсэн 4 төрлийн ур чадварын ангилал байх ба эдгээрт оношлон илрүүлэх, үнэлгээ хийх, удирдан зохион байгуулах болон аудит хийх/дүгнэлт гаргах ур чадвар багтана.

Тайлбар:

- ЭМШ Гэрчилгээ-2 эзэмшигчийн хувьд, 2-р ангиллын ЭМГ олгох зорилгоор хийх үзлэгтэй холбоотой ур чадвар.
- ЭМШ Гэрчилгээ-1 эзэмшигчийн хувьд, 1, 2 болон 3-р ангиллын ЭМГ олгох зорилгоор хийх үзлэгтэй холбоотой ур чадвар.
- Ур чадварын үзүүлэлт нь дараах 3 түвшинтэй байна:

мэдлэг	зөвхөн тухайн сэдвийн онолын мэдлэг
туршлага	тухайн этгээд хяналтан дор ажиллаж чадах бодит дадлага туршлага
эксперт	тухайн этгээд бие даан ажиллах болон бусдад хяналт тавих чадвартай.

Дараах хүснэгтэд ЭМШ Гэрчилгээ-1 болон ЭМШ Гэрчилгээ-2 эзэмшигчид шаардлагатай ур чадвар болон ур чадварын түвшний жагсаалтыг үзүүлсэн.

Шаардлагатай ур чадварын тодорхойлолт	Ур чадварын түвшин	
	ЭМШ-1	ЭМШ-2
Оношлон илрүүлэх		
1. Дараах мэдээлэл болон чадвараа ашиглан нисэхийн үйл ажиллагааны орчинд сөргөөр нөлөөлөх боломжтой нөхцөл байдлыг үнэн зөв оношилж, дүгнэлт гаргах эмчилгээний ур чадвараа ашиглаж чаддаг байх: <ul style="list-style-type: none"> • эмчилгээний түүх: • бие махбодын болон сэтгэцийн үзлэг: • нэмэлт шинжилгээ судалгаа, эсхүл зөвлөхийн дүгнэлт гаргах (ЭМШ гүйцэтгэсэн, эсхүл зохион байгуулсан): • оношлох ур чадвар: • хамтран ажиллагсад, бусад эрүүл мэндийн мэргэжилтэн болон байгууллагатай хамтран ажиллах. 	эксперт	эксперт
2. Хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн нөхцөл, эсхүл нисэхийн үйл ажиллагааны орчинд аюултай үйлдэл хийх шалтгаан болох нөхцөл байдлын хүчин зүйлийг олж тогтоох	эксперт	туршлагатай
3. Эрүүл мэндийн практик зохицуулалтын ашиг сонирхлын зөрчил, эсхүл өрсөлдөөнийг илрүүлж, тогтоох	туршлагатай	туршлагатай
4. Хүсэлт гаргагчийг, нисэхийн үйл ажиллагааны орчинд аюулгүй ажиллах шаардлага хангахад тохирч байгаа эсэхэд үнэлгээ хийх зорилгоор эх сурвалжаас нэмэлт мэдээлэл авч чаддаг байх. Жишээ нь сэтгүүл, шинжлэх ухааны судалгааны тайлан, интернетийн эх сурвалж, хамтран ажиллагсад болон тусгай мэргэжлийн зөвлөх, багш зэрэг.	туршлагатай	туршлагатай
Үнэлгээ хийх		
5. Хүсэлт гаргагчийг нисэхийн үйл ажиллагааны орчинд аюулгүй ажиллахад тохиромжтой эсэхийг тодорхойлох болон дүгнэлт хийхдээ баримт нотолгоонд суурилсан анагаахын зарчим, үйл явцыг ашигладаг байх.	эксперт	туршлагатай
6. Нисэхийн үйл ажиллагааны орчинд ажиллах хүсэлт гаргагчийн аюулгүй, нийцтэй байдлыг тогтоохтой холбоотой хууль дүрэм, болон эрүүл мэндийн хууль эрх зүйн анхаарах асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг байх.	туршлагатай	туршлагатай
7. Хүсэлт гаргагчийг, нисэхийн үйл ажиллагааны орчинд аюулгүй ажиллах шаардлага хангахад тохирч байгаа эсэхэд үнэлгээ хийх зорилгоор нэмэлт мэдээлэл болох мэргэжлийн сэтгүүл, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, интернетийн эх сурвалж, хамтран ажиллагсад, мэргэжлийн зөвлөгч ашиглах ба шүүмжлэлтэйгээр дүн шинжилгээ хийдэг байх.	туршлагатай	туршлагатай
Удирдан зохион байгуулах		
8. Шаардлагатай стандарт, арга аргачлал болон процессыг ашиглан нисэхийн үйл ажиллагааны орчинд ажиллаж байгаа хүсэлт гаргагчтай холбоотой эрсдэлд үнэлгээ хийх	эксперт	эксперт
9. Зөрчилдөж, эсхүл өрсөлдөж байгаа ашиг сонирхлыг нисэхийн аюулгүй байдалд, эсхүл эмчилгээний шийдвэрийн чанарт нөлөөлөхгүй хэлбэрээр зохицуулах	эксперт	туршлагатай

Шаардлагатай ур чадварын тодорхойлолт	Ур чадварын түвшин	
	ЭМШ-I	ЭМШ-II
<p>10. Үр дүнтэй харилцаа холбоо:</p> <ul style="list-style-type: none"> хүсэлт гаргагч, ИНЕГ, хамтран ажиллагсад болон бусад байгууллагад чиглэсэн эрсдэлийн үнэлгээ болон, шаардлагатай асуудлыг тодорхойлох. хүсэлт гаргагчтай холбоотой хууль, дүрмийн талаар мэдээлэлтэй байх. эрсдэлийн удирдлагын шийдвэрийн зохицуулалтын талаар нэмэлт мэдээлэл, зөвлөмж болон зааварчилгаа авах зорилгоор хамтран ажиллагсад, зөвлөгч болон бусад хүмүүстэй харилцах. 	эксперт	эксперт
<p>11. Бүртгэлийн систем болон захиргааны ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулах:</p> <ul style="list-style-type: none"> эрсдэлийн үнэлгээний, эрсдэлийн удирдлагын шийдвэрийн болон арга хэмжээний зохицуулалтыг найдвартай, нягт нямбай бүртгэсэн байх эрсдэлийн үнэлгээний болон эрсдэлийн удирдлагын шийдвэрийн зохицуулалт нь хоёрдмол утга агуулгагүй, үр дүнтэй байх эрсдэлийн үнэлгээний, эрсдэлийн удирдлагын шийдвэрийн зохицуулалт болон арга хэмжээний зохицуулалт нь хэдийд ч буцаан сэргээгдэхүйц байх 	эксперт	эксперт
<i>Дүгнэлт гаргах / аудит хийх</i>		
<p>12. Мониторинг хийх, дүгнэлт гаргах болон аудитын үйл ажиллагаанд бүтээлчээр оролцдог байх, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> дүгнэлт гаргах үйл явцад идэвхтэй оролцох дүгнэлтээр илэрсэн алдаа дутагдал, үр дүнг эерэгээр үнэлж, хүлээн авах дүгнэлтийн зөвлөмжийг хэрэгжүүлэх 	туршлагатай	туршлагатай

--oOo--